



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанид дизелийн түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Г.Болдсайхан  
/Хангамж үйлчилгээ хариуцсан дэд захирал/

Нарийн бичгийн дарга: М.Энхбат  
/Худалдан авах ажиллагааны хэсгийн ахлах мэргэжилтэн/

Гишүүд: Г.Ариунболд  
/Түлш дамжуулах цехийн дарга/  
Э.Мөндөр  
/Монголын эрчим хүчний мэргэшсэн инженерүүдийн зөвлөлийн гишүүн/  
Ж.Ханд-Иш  
/Монголын эрчим хүчний мэргэшсэн инженерүүдийн зөвлөлийн гишүүн/

2. Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн тендерийн ажиллагааг явуулж, үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг захиалагчид танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Г.Болдсайхан /-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэх, Үнэлгээний хорооны гишүүдийн мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч компанийн эрх бүхий албан тушаалтанд хугацаанд нь бүртгүүлэхийг нарийн бичгийн дарга /М.Энхбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.A4.2019

0010000350



